

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Амармэнд

Утас: 70453721, Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/41/НА-СТА-ТЦЗ
танай _____ -ны № _____ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЦОГТ-ОЧИР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь сахилгын шийтгэлтэй нэр бүхий 5 албан хаагчаас 1,132.3 мянган төгрөгийн суутгалыг дутуу суутгасан, 3 албан хаагчид 2,450.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон, анхан шатны баримтгүйгээр 1,551.5 мянган төгрөгийн 141кг махыг шууд зарлагадсан зөрчил нь санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг, түлш халаалтын зардлаас хувь хүнээс суутган тооцсон 2,056.6 мянган төгрөгийн ашгийн татварыг төлсөн, хоолны зардлаас ахмадуудад хүндэтгэл үзүүлэх 540.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн алдаа зөрчил нь санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200200211

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,314,880.96	25,808,286.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	180,983.00	921,249.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	180,983.00	68,169.00
335	Бусад авлага	00.00	853,080.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	853,080.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,133,897.96	24,887,037.80
354	Хангамжийн материал	24,133,897.96	24,887,037.80
35410	Бичиг хэргийн материал	00.00	730,000.00
35420	Аж ахуйн материал	14,378,389.80	14,614,789.80
35440	Түлш, шатах тослох материал	750,000.00	1,920,000.00
35460	Хүнсний материал	2,895,508.16	1,512,248.00
35470	Бусад хангамжийн материал	6,110,000.00	6,110,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,490,892,467.62	2,404,670,846.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,490,892,467.62	2,404,670,846.57
392	Биет хөрөнгө	2,278,375,769.26	2,198,674,148.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,214,765,995.00	2,214,765,995.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-110,858,142.84	-176,487,853.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,998,000.00	49,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,998,000.00	-49,998,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	239,810,169.10	254,917,269.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-178,546,932.68	-197,254,316.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	196,926,474.95	211,001,474.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-83,721,794.27	-108,268,420.19
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,994,600.00	1,994,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,994,600.00	-1,994,600.00
393	Биет бус хөрөнгө	212,516,698.36	205,996,698.32
39301	Программ хангамж	9,726,900.00	9,726,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,170,201.64	-9,690,201.68
39303	Бусад биет бус хөрөнгө	205,960,000.00	205,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,515,207,348.58	2,430,479,133.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	571,688.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	571,688.00
413	Өглөг	00.00	571,688.00
4136	Бусад өглөг	00.00	571,688.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	571,688.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,515,207,348.58	2,429,907,445.37
51	Засгийн газрын хувь оролцоо	2,515,207,348.58	2,429,907,445.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	454,364,609.51	454,364,609.51
51101	Өмч: - төрийн	454,364,609.51	454,364,609.51
512	Хуримтлагдсан үр дүн	1,804,540,034.58	1,719,240,131.37
51210	Өмнөх үеийн үр дүн	1,804,540,034.58	1,804,540,034.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-85,299,903.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	256,302,704.49	256,302,704.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,515,207,348.58	2,430,479,133.37

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

20
САНАЛ ДҮГНЭЛТ

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,270,271,157.00	1,061,082,954.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,033,772,100.00	1,032,948,054.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	964,786,200.00	966,191,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	964,786,200.00	966,191,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,985,900.00	66,756,554.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	19,500,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	32,293,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,892,000.00	22,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,593,900.00	12,463,254.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,164,155,166.24	1,146,382,857.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,164,155,166.24	1,146,382,857.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,157,715,753.24	1,136,176,989.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	715,219,036.70	706,595,072.00
210101	Үндсэн цалин	630,792,436.70	508,246,466.00
210102	Нэмэгдэл	72,180,000.00	149,230,431.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,246,600.00	49,118,175.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,602,922.30	92,355,948.00
210201	Тэтгэврийн даатгал	35,474,782.00	65,423,009.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,548,148.00	7,048,681.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	40,872,992.30	5,688,616.00
210204	Ажилгүйдлийн даатгал	700,800.00	1,297,314.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,006,200.00	12,898,328.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,420,024.00	126,010,097.00
210301	Гэрэл, цахилгаан	9,333,652.00	9,771,644.00
210302	Түлш, халаалт	111,006,372.00	114,543,463.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	1,694,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,791,688.00	42,905,736.00
210401	Бичиг хэрэг	13,197,525.00	12,270,115.00
210402	Тээвэр, шатахуун	11,813,850.00	14,733,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,352,977.00	3,039,154.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	292,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,119,872.00	12,571,157.00
210408	Бараа материал акталсны зардал	6,957,464.00	00.00
2105	Нормативт зардал	67,832,139.00	47,091,165.16
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	189,500.00	127,000.00

Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	64,810,639.00	41,464,765.16
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,832,000.00	5,499,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,761,000.00	1,394,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,761,000.00	00.00
210604	Урсгал засвар	00.00	1,394,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,526,500.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,526,500.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,872,292.00	4,421,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,657,031.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	512,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	259,830.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,603.00	37,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	422,600.00	1,625,100.00
210807	Газрын төлбөр	1,822,228.00	1,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,690,151.24	115,403,721.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	376,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	87,314,151.24	115,403,721.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,439,413.00	10,205,868.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,077,203.00	4,055,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,077,203.00	4,055,720.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	362,210.00	6,150,148.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	362,210.00	6,150,148.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	106,115,990.76	-85,299,903.21
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	106,115,990.76	-85,299,903.21

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,082,140,600.00	1,033,263,654.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,368,500.00	315,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	48,368,500.00	315,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,368,500.00	315,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,368,500.00	315,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,033,772,100.00	1,032,948,054.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	964,786,200.00	966,191,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	964,786,200.00	966,191,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,985,900.00	66,756,554.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	19,500,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	32,293,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,892,000.00	22,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,593,900.00	12,463,254.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,071,676,300.00	1,031,900,854.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,071,676,300.00	1,031,900,854.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,065,212,887.00	1,021,519,906.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	706,871,142.00	706,407,434.00
210101	Үндсэн цалин	523,901,837.90	508,058,828.00
210102	Нэмэгдэл	143,414,904.10	149,230,431.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,554,400.00	49,118,175.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,131,800.00	92,430,772.00
210201	Тэтгэврийн даатгал	69,106,400.00	65,335,720.83
210202	Тэтгэмжийн даатгал	7,006,300.00	7,135,970.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,605,100.00	5,688,616.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,401,200.00	1,297,314.85
210205	Эрүүл мэндийн даатгал	14,012,800.00	12,973,149.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,732,749.00	129,236,714.00
210301	Гэрэл, цахилгаан	9,333,652.00	9,771,644.00
210302	Түлш, халаалт	110,319,097.00	117,770,080.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	1,694,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,103,074.00	43,225,136.00
210401	Бичиг хэрэг	13,080,700.00	12,953,615.00
210402	Тээвэр, шатахуун	11,822,750.00	14,733,310.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,352,977.00	3,039,154.00

Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	452,500.00	292,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,394,147.00	12,207,057.00
2105	Нормативт зардал	72,042,186.00	44,498,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	189,500.00	127,000.00
210502	Хоол, хүнс	65,195,686.00	38,602,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,657,000.00	5,769,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,656,900.00	1,300,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,752,400.00	00.00
210604	Урсгал засвар	1,904,500.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,526,500.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,526,500.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,772,536.00	4,421,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,557,275.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	512,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	259,830.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,603.00	37,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	422,600.00	1,625,100.00
210807	Газрын төлбөр	1,822,228.00	1,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	376,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	376,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,463,413.00	10,380,948.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,101,203.00	4,230,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,101,203.00	4,230,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	362,210.00	6,150,148.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	362,210.00	6,150,148.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,464,300.00	1,362,800.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,464,300.00	1,362,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,464,300.00	1,362,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,464,300.00	1,362,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,464,300.00	1,362,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,464,300.00	-1,362,800.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	454,364,609.51	256,302,704.49	1,698,424,043.82	00.00	2,409,091,357.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	454,364,609.51	256,302,704.49	1,698,424,043.82	00.00	2,409,091,357.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	106,115,990.76	00.00	106,115,990.76
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	454,364,609.51	256,302,704.49	1,804,540,034.58	00.00	2,515,207,348.58
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	454,364,609.51	256,302,704.49	1,804,540,034.58	00.00	2,515,207,348.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	454,364,609.51	256,302,704.49	1,804,540,034.58	00.00	2,515,207,348.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-85,299,903.21	00.00	-85,299,903.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	454,364,609.51	256,302,704.49	1,719,240,131.37	00.00	2,429,907,445.37

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,070,441,500.00	960,816,291.00	109,625,209.00	89.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,070,441,500.00	960,816,291.00	109,625,209.00	89.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,066,210,300.00	956,585,491.00	109,624,809.00	89.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	700,635,800.00	700,635,800.00	0.00	100%
210101	Үндсэн цалин	531,783,200.00	502,712,057.00	29,071,143.00	94.5%
210102	Нэмэгдэл	144,359,600.00	148,805,568.00	-4,445,968.00	103.1%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,493,000.00	49,118,175.00	-24,625,175.00	200.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,585,800.00	91,770,472.00	3,815,328.00	96%
210201	Тэтгэврийн даатгал	67,560,400.00	64,675,420.83	2,884,979.17	95.7%
210202	Тэтгэмжийн даатгал	7,006,300.00	7,135,970.06	-129,670.06	101.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,605,100.00	5,688,616.28	-83,516.28	101.5%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,401,300.00	1,297,314.85	103,985.15	92.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	14,012,700.00	12,973,149.98	1,039,550.02	92.6%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,748,200.00	115,747,755.00	445.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	9,109,000.00	6,765,461.00	2,343,539.00	74.3%
210302	Түлш, халаалт	99,089,200.00	107,287,304.00	-8,198,104.00	108.3%
210303	Цэвэр, бохир ус	7,550,000.00	1,694,990.00	5,855,010.00	22.5%
2104	Хангамж, бараа материалын зардал	29,227,000.00	7,125,814.00	22,101,186.00	24.4%
210401	Бичиг хэрэг	7,838,800.00	1,838,800.00	6,000,000.00	23.5%
210402	Тээвэр, шатахуун	10,538,600.00	2,038,600.00	8,500,000.00	19.3%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,462,000.00	1,460,814.00	1,186.00	99.9%
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00	100,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	992,000.00	292,000.00	700,000.00	29.4%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,295,600.00	1,495,600.00	6,800,000.00	18%
2105	Нормативт зардал	85,821,600.00	36,521,600.00	49,300,000.00	42.6%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	927,000.00	127,000.00	800,000.00	13.7%
210502	Хоол, хүнс	76,625,200.00	30,625,200.00	46,000,000.00	40%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,269,400.00	5,769,400.00	2,500,000.00	69.8%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,362,800.00	1,362,800.00	9,000,000.00	13.2%
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,362,800.00	1,362,800.00	3,000,000.00	31.2%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	00.00	500,000.00	
210604	Урсгал засвар	5,500,000.00	00.00	5,500,000.00	
2107	Томилолт, зочны зардал	76,800.00	00.00	76,800.00	
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00	0.00	
210702	Дотоод албан томилолт	76,800.00	00.00	76,800.00	
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	0.00	

Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,752,300.00	3,421,250.00	25,331,050.00	11.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,850,000.00	00.00	23,850,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,783,200.00	806,400.00	976,800.00	45.2%
210803	Даатгалын үйлчилгээ	396,000.00	119,250.00	276,750.00	30.1%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00	37,500.00	160,500.00	18.9%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	33,000.00	67,000.00	33%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	625,100.00	625,100.00	0.00	100%
210807	Газрын төлбөр	1,800,000.00	1,800,000.00	0.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4231200.00	4230800.00	400.00	100%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	0.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,231,200.00	4,230,800.00	400.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,231,200.00	4,230,800.00	400.00	100%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00	0.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,070,441,500.00	960,816,291.00	109,625,209.00	89.8%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	966,191,500.00	960,816,291.00	5,375,209.00	99.4%
131001	Улсын төсвөөс санхүүжих	966,191,500.00	960,816,291.00	5,375,209.00	99.4%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	104,250,000.00	00.00	104,250,000.00	
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	104,250,000.00	00.00	104,250,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00		
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	00.00	66.00		
620001	Удирдах ажилтан	00.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	65.00		
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00		
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00		

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		67,072,154.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		67,072,154.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		66,297,215.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,771,634.00
210101	Үндсэн цалин		5,346,771.00
210102	Нэмэгдэл		424,863.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		660,300.00
210201	Тэтгэврийн даатгал		660,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		13,488,959.00
210301	Гэрэл, цахилгаан		3,006,183.00
210302	Түлш, халаалт		10,482,776.00
2104	Хангамж, бараа материалын зардал		36,099,322.00
210401	Бичиг хэрэг		11,114,815.00
210402	Тээвэр, шатахуун		12,694,710.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,578,340.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		10,711,457.00
2105	Нормативт зардал		7,977,000.00
210502	Хоол, хүнс		7,977,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,300,000.00
210604	Урсгал засвар		1,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,000,000.00
210807	Газрын төлбөр		00.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		774,939.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		774,939.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		66756554.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		66,756,554.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		32,293,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		22,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		12,463,254.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хэрэгжүүлэгч агентлаг юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4,656.6 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,146,382.8 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 5,731.9 мянган төгрөгийн 80 хувиар буюу 4,585.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,238.6 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	180.9	921.2	740.3
Бараа материал	24,133.8	24,887.0	753.2
Үндсэн хөрөнгө	2,490,892.4	2,404,670.8	-86,221.6
Нийт хөрөнгө	2,515,207.3	2,430,479.1	-84,728.2
Өр төлбөр	0.0	571.6	-571.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,515,207.3	2,429,907.4	-85,299.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,515,207.3	2,430,479.1	-84,728.2

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 921.2 мянган төгрөг байгаа нь бусад зардлын тооцооны авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24,887.0 мянган төгрөг болж 753.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бичиг хэргийн материал байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,404,607.8 мянган төгрөг болж 86,221.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 115,403.7 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 1,362.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хандиваар хүлээн авсан 27,819.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.

Тайлант онд хувь хүмүүст төлөх 571.6 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,429,907.4 мянган төгрөг болж 85,299.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 209,188.2 мянган төгрөгөөр буюу 16.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөрийн данс байна.

Нийт зардал өмнөх оноос 17,772.3 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Үүнд нормативт зардал, хангамжийн бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,168,747.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,168,747.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 101,037.7 мянган төгрөгөөр бууруулан 1,067,709.3 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 2,732.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,070,441.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 966,191.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 104,250.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 966,191.5 мянган төгрөг, ийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 960,816.2 мянган төгрөгийг зарцуулж 5,375.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 960,816.2 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн төсвөөс 32,293.3 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 22,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12,463.2 мянган төгрөгийн орлого орж 66,756.5 мянган төгрөгийг зарцуулж 774.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгсөн тул А/108 дугаар тушаалаар өгсөн ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар нарийвчилсан горим хэрэгжүүлэхэд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 154,841.2 мянган төгрөгийн 4 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 20,624.2 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан зөрчил илэрлээ.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 127, хугацаа хоцроосон 22, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 327 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг анхааран үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 199,435.3 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 9,529.4 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 5,133.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 178,062.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 6,710.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин цалин, бичиг хэрэг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, шуудан холбоо, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг шууд зардалд бүртгэсэн 9,529.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.2 дахь заалтад “Үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 зүйлийн 20.1.4 заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчин сахилгын шийтгэлтэй нэр бүхий 5 албан хаагчаас 1,132.3 мянган төгрөгийн суутгалыг дутуу суутгасан, 3 албан хаагчид 2,450.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байсанд тус тус төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.
2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” 20 зүйлийн 20.1.4 заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчин санхүүгийн

тайланд үндэслэх анхан шатны баримтгүйгээр 1,551.5 мянган төгрөгийн 141кг махыг шууд зарлагадсаныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

1. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, тухайн үед мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын хавсралтад заасан эдийн засгийн ангиллыг хэрэгжүүлэн ажиллахгүйгээр түлш халаалтын зардлаас хувь хүнээс суутган тооцсон 2,056.6 мянган төгрөгийн ашгийн татварыг төлсөн, хоолны зардлаас ахмадуудад хүндэтгэл үзүүлэх 540.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн алдаа зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.
2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтад заасан “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг зөрчин орлогын 154,841.2 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 20,624.2 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. Иймд шилэн дансны тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж хугацаа хоцроохгүй байх алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалтад “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно”, 2.4-т “Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална” гэж заасныг тус тус зөрчин нэр бүхий 6 албан хаагчдад 5,002.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.
- 1.2. Тухайн үед мөрдөгдөж байсан Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна” гэж заасныг зөрчин удирдлагын шийдвэргүйгээр зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй гэж нягтлан бодогч өөртөө 1,708.0 мянган төгрөгийн амралтын цалинг 6 дугаар сард авсан байна. Удирдлагын шийдвэрийг 2021 оны 12 дугаар сарын 28-нд нөхөн гаргасан байна.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйл, Засгийн газрын тогтоол 2019 оны 5 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	6	199,435.3	1	9,529.4	2	5,133.9	2	178,062.0	1	6,710.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Handwritten signatures and a red square stamp are present over the names of the auditors.

/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Г.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 25-ны өдөр